

**“Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийн хүрээнд Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг болон Сэлэнгэ, Баянхонгор аймгуудын төрийн өмчийн цэцэрлэгүүд, өрхийн эмнэлгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан дэд бүтцийн засварын ажлын зураг, төсөв хийх ажлын удирдамж**

## 1. Ажлын үндэслэл, хэрэгцээ

Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Хөтөлбөр нь 2024 оноос эхлэн Японы Гадаад Харилцааны Яамны Төрийн бус байгууллагыг дэмжих хөтөлбөрийн санхүүжилтээр Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг болон Баянхонгор, Сэлэнгэ аймгуудын төрийн өмчийн цэцэрлэг, өрхийн эмнэлгүүдэд “Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийг хэрэгжүүлж байна.

Энэхүү төсөлд 2025 онд шинээр хамрагдах цэцэрлэг, өрхийн эмнэлгүүдийн орчин, дэд бүтцийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцүүлэн сайжруулах зорилгоор ариун цэврийн өрөөг засварлах, тэргэнцэртэй хүүхдэд зориулсан налуу зам, шатны зориулалтын бариул хийж тоноглох зэрэг шаардлагатай байгаа юм. Уг засварын ажилд 5 цэцэрлэг, 5 өрхийн эмнэлэгт хийгдэх дараах ажлууд багтсан болно.

## 2. Гүйцэтгэх ажил

	Байгууллага	Хийгдэх ажил
1.	БЗД-ийн 320 дугаар цэцэрлэг	1) Цэцэрлэгийн байрны 2-3 дугаар давхар хоорондын шатанд дэмжих бариул угсрах 2) 4 ангийн ариун цэврийн өрөөнд тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан суултуур, угаалтуур, туслах тоноглолын хамт тус бүр 1 ш шинээр хийлгэх 3) Цэцэрлэгийн хажуу талын орох хаалганы шатанд налуу зам, туслах бариулын хамт хийлгэх
2.	БЗД-ийн “Нэмүүлэн” өрхийн эмнэлэг	1) Гадна талын налуу замын баруун талын хананд туслах бариул хийлгэх
3.	Баянхонгор аймгийн 1 дүгээр цэцэрлэг	1) Цэцэрлэгийн байрны давхар хоорондын шатанд дэмжих бариул угсрах Гадна талын налуу замыг стандартын дагуу засварлаж, туслах бариулын хамт хийлгэх
4.	Баянхонгор аймгийн “Оточ манал” өрхийн эмнэлэг	1) Ариун цэврийн өрөөг засварлаж нэмэлтээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан угаалтуур, суултуур туслах тоноглолыг хийлгэх 2) Барилгын орох хаалганы довжоонд налуу зам хийлгэх
5.	СХД-ийн 81 дүгээр цэцэрлэг	1) Цэцэрлэгийн барилгын гадна хажуу талын хаалганы шатанд налуу зам болон туслах бариул хийлгэх 2) Цэцэрлэгийн 1 ангийн ариун цэврийн өрөөнд зориулалтын суултуур, угаалтуур, туслах тоноглолын хамт шинээр хийлгэх

		3) Цэцэрлэгийн гадна талын хашааны хаалганы шатанд налуу зам, туслах бариулын хамт хийлгэх Дотор талын шатанд хүүхдийн аюулгүй байдлыг хангасан хулдаасан бүрхэвч хийлгэх
6.	СХД-ийн “Анан” өрхийн эмнэлэг	1) Өрхийн эмнэлгийн 2 ариун цэврийн өрөөний довжоонд налуу зам суулгаж, туслах хэрэгслээр тоноглох Сэргээн засах эмчилгээний өрөөг засварлаж, туслах бариул хийлгэх
7.	ЧД-ийн “Мэнд аривжих” өрхийн эмнэлэг	1) Дотор талын шатанд туслах бариул хийлгэх
8.	ЧД-ийн 83 дугаар цэцэрлэг	1) Цэцэрлэгийн 2 ангийн ариун цэврийн өрөөнд тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан суултуур, угаалтуур, туслах тоноглолын хамт хийлгэх 2) Цэцэрлэгийн гол коридорын хананд туслах бариул хийлгэх 3) Цэцэрлэгийн нэг талын шатанд туслах бариул хийлгэх 4) Цэцэрлэгийн гадна талын налуу замыг стандартын дагуу засварлаж, туслах бариул хийлгэх 5) Цэцэрлэгийн гадна талын талбайн шатанд налуу зам туслах бариулын хамт хийлгэх
9.	Сэлэнгэ аймгийн 3 дугаар цэцэрлэг	1) Цэцэрлэгийн гол коридорын хананд туслах бариул хийлгэх 2) Цэцэрлэгийн зүүн талын шатанд туслах бариул хийлгэх 3) Цэцэрлэгийн дээд, доод давхрын 2 ангийн ариун цэврийн өрөөнд тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулалтын суултуур, угаалтуур, туслах тоноглолын хамт шинээр хийлгэх 4) Цэцэрлэгийн гол хаалганы довжоонд налуу зам суулгах, гадна талын налуу замд туслах бариулын хийлгэх 5) Цэцэрлэгийн ард талын хаалганд налуу зам туслах бариулын хамт хийлгэх
10.	Сэлэнгэ аймгийн “Номт Хан” өрхийн эмнэлэг	1) Өрхийн эмнэлгийн гол коридорын хананд туслах бариул хийлгэх 2) Өрхийн эмнэлгийн үүдний хэсэгт байгаа довжоог засварлаж, тэргэнцэртэй хүн зорчих боломжтой болгох 3) Өрхийн эмнэлгийн жорлонд хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан зориулалтын угаалтуур, суултуур, туслах тоноглолын хамт суулгах 4) Гадна талын хаалганы налуу замыг стандартын дагуу засварлаж, туслах бариул хийлгэх 5) Дотор талын хананд туслах бариул хийлгэх

### 3. Засварын ажлын хүрээ

- Төсөлд хамрагдах цэцэрлэг, өрхийн эмнэлэг дээр очиж шаардлагатай техникийн хэмжилтүүдийг хийх
- Цэцэрлэг, өрхийн эмнэлгийн удирдах ажилтнуудтай уулзаж, засварын ажлын талаарх нарийвчилсан мэдээлэл авах
- Байгууллага тус бүрээр засварын ажлын техникийн зургийг бэлтгэх

- Байгууллага бүрээр засварын ажлын төсвийн тооцоог барилгын төсөв зохиогчийн нормативын дагуу боловсруулах
- Байгууллага бүрээр барилгын засварын ажлын мэдүүлэг хуудсыг бэлтгэх

#### 4. Зөвлөх ажлын хугацаа

Зөвлөх ажлын нийт хугацаа ажлын 20 хоног байна.

Гүйцэтгэх ажил	Хугацаа
Зөвлөх ажлын нөхцөлийн талаар тохиролцож, гэрээнд гарын үсэг зурах	2024.06.25
Төсөлд хамрагдах байгууллагууд дээр очиж шаардлагатай техникийн хэмжилтүүдийг хийх, нарийвчилсан мэдээлэл цуглуулах	2024.06.25-2024.06.30
<ul style="list-style-type: none"> <li>• Байгууллага тус бүрээр засварын ажлын техникийн зургийг бэлтгэх</li> <li>• Дээрх засварын ажлын төсвийн тооцоог барилгын төсөв зохиогчийн нормативын дагуу боловсруулах</li> <li>• Байгууллага бүрээр барилгын засварын ажлын мэдүүлэг хуудсыг бэлтгэх</li> </ul>	2024.06.30-2024.07.09
Боловсруулсан материалуудыг ХИС-нд цаасаар болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгөх	2024.07.10
Захиалагчийн хүсэлтээр боловсруулсан материалыг хянан засварлах, сайжруулах	2024.07.17-2024.07.27

#### 5. Барилгын компанид тавигдах ерөнхий шаардлага

- Барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээтэй байх
- Сургууль, цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулах, барих, засварлах чиглэлээр 5 буюу түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх
- Хийгдэх барилгын засварын ажлын зураг, төсөв хийх хүний нөөцтэй байх

#### 6. Хүлээн авах материал

- Шалгаруулалтад оролцох хүсэлт илэрхийлсэн албан бичиг
- Байгууллагын танилцуулга
- Байгууллагын гэрчилгээний хуулбар
- Гүйцэтгэх ажлын үнийн санал